1 - Археологийн урьдчилсан хайгуул судалгааны ажлаар илэрсэн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй дурсгалуудыг мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх	- Археологийн урьдчилсан хайгуул судалгааны ажлаар төслийн талбайд илэрсэн Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш-2ш, чулуун дараастай монгол үеийн булш-2ш, Хүннүгийн үеийн булш-1ш, он цаг тодорхойгүй булш-1ш нийт 6 тооны булшийг авран хамгаалах малтлага судалгааны ажлыг ШУТИС-БУХС-тай хамтран ажиллахаар гэрээ хийгдэн ажиллаж байна.




Зураг 25. Археологичид малтлага судалгааны ажлаа хийж буй нь

2.4 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвөлгөө		Гүйцэтгэл
1	-Сум орон нутгаас тавьсан саналын дагуу ажлыг гүйцэтгэх	-Даланжаргалан сумын Билүүт багийн иргэдийн тавьсан саналын дагуу малчин Ариунболд, Мягмарсүрэн нарын өвөлжөөний хорооны хөрзөнг хуулж хорооны ард байсан элсийг хусаж цэвэрлэв мөн нутгийн ард иргэдийн худгийн ойр орчмыг техникээр хусаж цэвэрлэв. Даланжаргалан сумын ЗДТГ-ын тавьсан саналын дагуу “Гамшигаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилт”-ыг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллах ажилд компаний ажилчидаас оролцсон.
2	- Тэрбум мод аяны хүрээнд 500 ширхэг мод уурхайн хашаанд тарих	- Тэрбум мод аяны хүрээнд уурхайн хашаанд тарьсан байсан модны зэрэгцээ шинээр 500 ширхэг мод суулгасан.
3	- “Их Нарт” БНГ-ын захиргаатай хамтран ажиллаж Их нартын БНГ-т худаг гаргах.	- “ Их Нарт БНГ-ын захиргаатай хамтран, Их нартын БНГ-т худаг гаргаж өгсөн.
4	- Орон нутгийн захиргаа “Их нарт” БНГ-тай хамтран ажиллаж хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	- Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх зорилгоор компанийн бүх ажилчидад сургалт орсон. Мөн Их Нарт байгалийн нөөц газартай хамтран ажилласан.



Зураг 26. Гамшигаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын бэлтгэл ажилд оролцож буй нь



Зураг 27. Малчин Ариунболдын хорооны хөрзөн хуулж байгаа нь



Зураг 28. Малчин Мягмарсүрэнгийн хорооны хэрзэнг хуулж байгаа нь



Зураг 29. Нутгийн иргэдэд зориулсан худгийн ойр орчмыг цэвэрлэж байгаа нь



Зураг 30. Тэрбум мод аяны хүрээнд 500ш мод тарьсан

2.5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших 2 малчин өрхтэй 2021 онд “Малчдыг нүүлгэн шилжүүлэх гэрээ” –г байгуулан сум орон нутгаас зөвшөөрсөн газарт нүүлгэн шилжүүлэх шаардлагатай байсныг гурвалсан гэрээ байгуулж нүүлгэн шилжүүлэх ажлыг компаний техник болон ажилчидаар нүүлгэж шинээр хороо барьж өгсөн.

Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд ямар нэгэн айл өрх аж ахуйн нэгж байхгүй учир нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд ажил тусгагдаагүй.

2.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1 -Бүх ажилчдыг хамруулсан гал түймэр унтраах, онцгой байдлын үед ажиллах тактикийн сургалт явуулах	-Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар компанийн дотоод дүрэм журмын батлуулж бүх ажилчидад сургалт орж мөрлөг болгон ажиллаж байна.
2 - Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах	- Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгсэл, галын сараалжуудыг компанийн дотоод хяналтын ажилчид сар бүр тогтмол үзлэг шалгалт хийж байна. Шаардлагатай тохиодолд засаж сайжруулах ажлууд хийгдсэн.
3 - Шатахууны болон тэсрэх бодисын агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавих	- Тэсрэх бодисын агуулахад 24 цагаар тогтмол гэрээт компанийн харуулууд хяналт тавин ажиллаж байна. Шатахууны агуулахад ШТС-н эрхлэгч аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна.
4 - Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	- Ажил гүйцэтгэж байгаа бүх ажилчид ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагаа болон гүйцэтгэх ажлын зааварчилгааг тогтмол авч ажилд гарч байна.
5 - ХАБЭА-н мэргэжилтэний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг компаний ХАБЭА-н жилийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	- Компаний бүх ажилчид ХАБЭА-н төлөвлөгөөт сургалтуудад хамрагдаж байна.
6 Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	-Үйлдвэрийн бүх хүнийг ажлын хувцас болон хөдөлмөр хамгаалах нэг бүрийн хэрэгсэлээр ханган ажиллаж байна.

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

КААХ-012		ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ		
“ОЛОН ИХТ БАЯН” ХХК		Ажилтны нэр	Гарын үсэг	Огноо
БАТАЛСАН	Уурхайн дарга	<i>О. Доржиев</i>		2021.11.20
ХЯНАСАН	Кемп менежер	<i>Б. Эрдмотор</i>		2021.11.19
БОЛОВСРУУЛСАН	ХАБЭА-н инженер	Л.Батсуурь	<i>Л.Батсуурь</i>	2021.11.20

Энэ зааварт оруулж буй аливаа өөрчлөлт нь уурхайн даргаар батлуулсан тохиолдолд хүчин төгөлдөрт тооцогдоно.

1. **Зорилго**

- 1.1. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж, болзошгүй гал түймрийн аюулын үед шаардлагатай арга хэмжээ авч, галын аюулгүй байдлыг хангах нь энэхүү зааварчилгааны гол зорилго юм.

2. **Цар хүрээ**

- 2.1. Хоолны газрын хэсэгт ажиллаж буй үндсэн болон гэрээт компанийн бүх ажилтанд хамаарна.

3. **Зааварчилгаа**

- 3.1. Шатамхай зүйлсийг гал тогооны цахилгаан төхөөрөмжүүд болон хоол хийх газраас хол байлга.
 Үүнд:
 ➤ Гарын алчуур,
 ➤ пиццаны хайрцаг,
 ➤ тогооны бариул эсхүл цаасан сав хайрцгийг цахилгаан зуух болон халуун төхөөрөмжүүдээс хол байлга.
- 3.1. Зуух, шарах шүүгээ болон агаар шүүгч дээр тогтсон тосыг тогтмол цэвэрлэ. Хүнсний тос амархан ноцож, нэн түргэн гал гаргадаг. Хайруулын таваг дээрхи бага зэргийн галыг унтраахын тулд таг буюу том хайруулын таваг дээр нь тавь. Тосны гал дээр ус эсхүл хуурай гурил бүү хий. Үүний улмаас гал улам ихэснэ. Шатаж буй савыг гадагш авч гарах буюу угаагуур руу хийх гэж бүү оролд. Гал түймэр тархан дэлгэрч болзошгүй.
- 3.2. Гал тогооны өрөөндөө савны таг, хүнсний сод болон гал унтраагуур ойрхон байлга.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ УРЬДЧИЛАН ХАНГААГҮЙ АЖИЛ
 ТИЙМ Ч ЧУХАЛ БИШ ГЭДГИЙГ ҮРГЭЛЖ САНАГТУН !!!

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Гал унтраагуурыг ажил эхлэгийн өмнө тогтмол шалгаж байх шаардлагатай.



*Их биений гадаад бүрэн бүтэн байдал(эвдэрсэн, цоорсон, хонхойсон)

*Хоолой, хошуу, яац түгжээний бүрэн байдал

*Даралтын зүүний заалт

*Гал унтраагуурын суурийн бүрэн бүтэн байдал.

Үзлэг шалгалтыг өдөр тутмын ажлын байрны үзлэгийн хуудас дээр тэмдэглэж хийж бичиж баталгаажуулсан байна.

- 3.3. Зуухны гал дээр хоол байх үед зуухны дээгүүр аливаа зүйл авах гэж бүү оролд. Байнга хэрэглэгддэг зүйлсийг зуухнаас хол байлга. Жигнэмэг болон амттанг зуухнаас хол байлга.
- 3.4. Сав суулганы бариулыг цааш нь харуулж хүнээс хол байрлуул. Цахилгаан утаснуудыг шүүгээний дээгүүр байрлуулж шалбарч гэмтсэн эсэхийг тогтмол шалга. Гэмтсэн утсыг нэн даруй солиулж аюулгүй болго.
- 3.5. Гал тогооны өрөөнд навсгар сул хувцас бүү өмс, хоол хийх үедээ цомхон аюулгүй хувцасла.
- 3.6. Гал дээр тавьсан хоолоо хараа хяналтгүй бүү үлдээ. Гал тогооны өрөөнөөс гарах шаардлага гарвал зуухны галаа багасгаж гал дээр хоол байгаагаа өөрт санагдуулах ямар нэг зүйл барьж яв.
- 3.7. Буцалж буй хоолтой савны тагийг авахдаа, ялангуяа бичил долгионы зуухнаас хоолоо гаргахдаа бие нүүрээ халуун уурнаас халхал эсхүл уурнаас хол байлга. Халуун уур түлэх аюултай.
- 3.8. Гал тогооны цахилгааныг сайн хянаж ажилла. Тогонд цохиулахаас гадна гал гарах аюул маш их.
- 3.9. Цахилгааны утаснуудыг байнга шалгаж бай. Буланд таарсан хэсгийг нь ялангуяа анхаар. Утас шалбарч гэмтсэн байж болзошгүй. Нэн даруй мэргэжлийн ажилтнаар сольж зас.
- 3.10. Олон салаалагч залгуур, уртасгагч залгуурыг хэт их ачаалахаас сэргийл. Хуучны цахилгаан холболттой бол мэргэжлийн хүнээр цахилгаан гүйдлийг байнга шалгуулж бай.
- 3.11. Угаагуур болон устай ойрхон ямарваа нэг цахилгаан төхөөрөмжийг бүү байрлуулж тавь.
4. **Галтай тэмцэхийн тулд юу анхаарах вэ!**
 - Галын аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ болон ослын гарцуудын байршилыг мэддэг байх
 - Гал унтраагуурын байршил болон хэрхэн хэрэглэх талаар мэддэг байх;
 - Гал гарсан тохиолдолд галын хэмжээнээс үл хамааран галын дохиоллыг ажиллуулла. Дохиолол байхгүй үед хэн нэгэнд мэдээлж тусламж хүс.
 - Утаатай орчноос зайлсхий
 - Бүх хүн гарсан эсэхийг шалга
 - Галтай тэмцэх оролдлого хийж болох нөхцөл
 - Дохиоллыг ажиллуулах, бусдаас тусламж эрэх
 - Гал бага хэмжээний бөгөөд хяналтандаа авч болохоор унтраах оролдлого хий
 - Та өөрөө гарах аюулгүй гарцтай (галд өртөхгүйгээр гарч болох) байх
 - Галын ангилалд тохирохуйц гал унтраагуурыг ашиглах
 - Галыг унтрааж чадахад эргэлзэж байгаа бол аюулгүйн зайд гар!
5. **Галын аюулын үед яаж дүрвэн гарах вэ?**
 - 5.1. Өрөөнөөс гарч буй сүүлийн хүн хаалгыг түгжилгүй хаагаад л орхих хэрэгтэй. Учир нь гал сөнөөгчид аврах ажлаа хийхэд нь саад болж болзошгүй.
 - 5.2. Хамгийн ойр дөт гарцаар гар.
 - 5.3. Утаа болон хорт хийнээс сэргийлэхийн тулд аль болох тонгойж доогуур яв. Шалтай ойр байх тусам агаар сийрэг байдаг тул хэрэгтэй бол мөлх.
 - 5.4. Боломжтой бол ам хамраа нойтон даавуугаар халхалвал амьсгалахад амар болно.
6. **Хэрэв та галд өртвөл ямар арга хэмжээ авах вэ?**
 - 6.1. Бүү сандар. Саруул ухаанаар бодох нь амиа аврахад чинь тус болно.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ УРЬДЧИЛАН ХАНГААГҮЙ АЖИЛ
ТИЙМ Ч ЧУХАЛ БИШ ГЭДГИЙГ ҮРГЭЛЖ САНАГТУН !!!

Зураг 31. Компаний мөрдөж буй галын аюулгүй байдлын зааварчилгаа



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ГАЛ УНТРААГУУРЫГ АШИГЛАХ ЗААВАР

ГАЛ УНТРААГУУРЫГ ХАДГАЛАХ, АШИГЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Шалнаас 1.3 - 1.5 метрийн түвшинд тавцан дээр юмуу өлгөсөн байдлаар нүдэнд харагдахуйц газар байрлуулна.
2. Хорыг гадаа ил задгай, цас борооны усанд норхуйцаар болон нарны шууд тусгал дор, халах хэрэгслийн ойр байлуулж болохгүй.
3. Гал унтраагуурыг жилд нэг удаа шалгана:
 - Их биений гадаад бүрэн бүтэн байдал (эвдэрсэн, цоорсон, хонхойсон);
 - Хоолой, хошууны, лац түгжээний бүрэн байдал;
 - Даралтын зүүний заалт;

ДОТОР БАЙРЛАХ ГАЛЫН КРАНТ

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЭМДЭГ

Гал унтраагуур	Галын крант	Ил гал тусгахад хорьгоо
Одоогийн гаралны тусгал	Галын эрсдэлтэй газруудад анхаарч байж	Талын гал тусгахад хорьгоо

ХЭРЭЭ ГАЛ ГАРВАЛ

Хамгийн ойр байрлах галын дохиоллыг нэрлэхүүн

Аюултай бүсэд байгаа хүмүүст аюулгүй газар очихыг анхааруул

Гал унтраах анги дууд

101



ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ САМБАР

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
 МОНГОЛ УРСЫН ГАЛЫН АЮУЛГҮЙ БААДЛЫН ХУУЛИАС

ГАЛЫН ТӨРӨЛ

- A** ШИГИЙН ШАТАМЖАЙ ХАЛУУ БИЭРИЙН МАТЕРИАЛ (Хүнс, ямаа, шувуу)
- B** ШАТАМЖАЙ ШИНГЭН (Шал, шүтлэг, материал, хөнгөвчлөгч, барилга)
- C** ШАХИРГААН ХЭРГЭСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ (Элс, цахилгаан)

ГАЛ ГАРАХ ШАЛТГААНУУД

- 1. Гал гарсныг тасгаар таслах
- 2. Гал гарсныг ус, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 3. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 4. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч

ГАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- 1. Гал гарсныг тасгаар таслах
- 2. Гал гарсныг ус, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 3. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 4. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч

ГАЛ УНТРААГУУР АШИГЛАХ ЗААВАР

- 1. Гал гарсныг тасгаар таслах
- 2. Гал гарсныг ус, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 3. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч
- 4. Гал гарсныг хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч, хөнгөвчлөгч

ТҮГЭЭМЭЛ ГАЛ УНТРААГУУР

ABC бол нунтаг гал унтраагуур бөгөөд булгарлын төрөлд тохиромжтой.

Нүүрс хүчлийн (Co2) нь машин механизм болон цахилгаанаас үүсдэг галд ихэвчлэн ашиглагддаг боловч энгийн шатамжийн галд харьцангуй үр дүн муутай байдаг.

ГАЛЫН ХОРНЫ БҮТЭЦ

- 1 Хөшүүрэг
- 2 Лац
- 3 Чагт
- 4 Даралт хэмжигч
- 5 Баллон
- 6 Сифон хоолой
- 7 Нунтаг цэнэг
- 8 Шүршигч хоолой

101 ГАЛ УНТРААХ АНГИ

НССТ КОМПАНИ
 НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ ХУВЦАС
 ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
 Утас: 8000304, 9130304 | Шуудан: 76010000@nsst.mn | E-mail: nsst@nsst.mn

Зураг 32. Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас, багаж хэрэгслүүд

“ОЛОН ИХТ БАЯН” ХХК
Баяжуулах үйлдвэрийн ААЗ-тай танилцсан ажилтны бүртгэл

Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зааварууд	Дугаар	Овог нэр	Албан тушаал	Огноо	Гарын үсэг
1 Бункер дээр ажиллах горим	Заавар№601	Оросоо Наранов	Баяжуулах үйлдвэр	09.01	<i>[Signature]</i>
2 Чичиргээг тэгжлэх горим	Заавар№602	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
3 Нархад зааварчилгаа өгөх горим	Заавар№603	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
4 Халарт булзур	Заавар№604	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
5 Ротор булзуурын горим	Заавар№605	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
6 Туузан гэжэгчийн горим	Заавар№606	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
7 Туузан конвейерийн горим	Заавар№607	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
8 Конусан булзуур дээр ажиллах горим	Заавар№608	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
9 Соронзон сепаратор ажиллах горим	Заавар№609	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
10 Тос барлаг төхөөрөмж дээр ажиллах горим	Заавар№610	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
11 Удирдлагын операторын зааварчилгаа	Заавар№611	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
12 Шингүүр дээр ажиллах горим	Заавар№612	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
13 Олворт ажиллах горим	Заавар№613	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
14 Тонот төхөөрөмжид засвар угсралтын ажил гүйцэтгэх горим	Заавар№614	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
15 Галын Аюулгүй Ажилгааны горим	Заавар№615	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
16 Ажлын байрны нэвэрлэгээ хийх ААны заавар	Заавар№616	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
17 Газар шорооны ажлын ААны горим	Заавар№617	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
18 Эвчэ хүлээх АА - ны горим	Заавар№618	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
19 Хакнигаан тоног төхөөрөмжийн тэжээлийг таслах, залгах аюулгүй ажиллагааны горим	Заавар№619	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
20 Хакнигаан хөдөлгүүрийн ашиглалтын АА-ны горим	Заавар№620	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
21 Хакнигааны байгууламжийн зиниглалтын АА-ны заавар	Заавар№621	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
22 Хакнигаан гүйцэтгэгчид зориулсан хакнигаан гүйцэтгэгч чөлөөлөх АА - ны горим	Заавар№622	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
23 Ачаа осоролгох дохионы аюулгүй ажиллагааны горим	Заавар№623	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
24 Технодогийн тоног төхөөрөмж засварлах аюулгүй ажиллагааны горим	Заавар№624	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
25 Хүчний кабель нугамын ашиглалтын АА - ны горим	Заавар№625	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
26 Хийн гагнуур хийх үеийн аюулгүй ажиллагаа	Заавар№626	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
27 Даралт сав хийн апараттай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	Заавар №27	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
28 Шат ашиглах үеийн аюулгүй ажиллагаа	Заавар №28	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
29 Хакнигаан багажтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	Заавар№29	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
30 Ачиг буулах ажил гарвар гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа	Заавар№30	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
31 Кранены мордох аюулгүй ажиллагаа	Заавар№31	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
32 Ачаа осорлох үед мордох аюулгүй ажиллагаа	Заавар№32	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
33 КРАНАА Р АЧАА ЗОХХ, БУУЛГАХ, ШИЛЖҮҮЛЭХ	Заавар№33	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
34 ГАР БАГАЖИУУДАЙ АЖИЛЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	Заавар№34	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
35 ГАГНУУР ХИЙХ	Заавар№35	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
36 Ны тал гаргах үед мордох	Заавар№36	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>
37 АЖЛЫН ТАЛГАРТ ТОСООЛОО ХИЙХ	Заавар№37	Оросоо Наранов	Оператор	09.01	<i>[Signature]</i>

Танилцуулсан ажилтны албан тушаал, овог нэр: *[Signature]* гарын үсэг: *[Signature]* огноо: 2023.09.01

Зураг 33. ХАБЭА-н албанаас компанийн бүх ажилчдад “Галын аюулгүй ажиллагааны горим” зааварчилгаа танилцуулж гарын үсэг зуруулсан

Галын хорны үзлэгийн хуудас

№	Техник, объектын нэр	Галын хорны төрөл	Тоо ширхэг	Галын хор		Тайлбар
				Хэвийн	Хэвийн бус	
1	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
2	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
3		Хүний үйлдвэр	1	✓		
4		Хүний үйлдвэр	1	✓		
5	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
6	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
7		Хүний үйлдвэр	2	✓		
8	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
9		Хүний үйлдвэр	2	✓		
10	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
11		Хүний үйлдвэр	2	✓		
12	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
13	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
14	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
15	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
16	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
17	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
18	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
19	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		- үзүүлэх
20	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
21	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		- үзүүлэх
22	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
23	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
24	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
25	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
26	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
27	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
28	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
29	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
30	Хүний үйлдвэр	Хүний үйлдвэр	2	✓		
31						
32						
33						
34						
35						
36						
37						

Огноо: 2023.08.02
Үзлэг хийсэн ХАБЭА-н инженер: *[Signature]*

Зураг 34. Галын хорны байршил, даралт шалгах үзлэгийн хуудас



Зураг 35. Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт орж буй нь



Зураг 36. Галын аюулын үед хэрэгжүүлэх тактикийн сургалт явуулж буй нь



Зураг 37. Уурхайн тэсрэх бодисын агуулахын тэмдэг тэмдэглэгээ

2.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1 - Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	-Ахуйн хаягдлыг 3 ангилж хогийн цэгт цуглуулан сумын нэгдсэн хогийн цэгт хүргэсэн. Ахуйн хог хаягдал хаях, зайлуулах гэрээг Даланжаргалан сумтай байгуулж сум, орон нутгийн төсөвт 6,000,000 төгрөг төлсөн.
2 - Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулах	-Техникийн хэрэглэгдэхгүй болсон хаягдал дугуй болон хаягдал төмрийг уурхайн тусгайлан бэлдсэн нэгдсэн цэгт хурааж төвлөрүүлж байна.
3 -Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулах	-Техникийн засвар үйлчилгээг тогтмол засварын төвд хийж байгаа бөгөөд засвартай сангийн шугамаар холбогдсон зориулалтын нөөцийн саванд цуглуулан хадгалж байна.
4 - Хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	- Уурхайгаас гарч байгаа хог хаягдлыг тогтмол бүртгэл хийж байна.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энгийн болон ахуйн хог хаягдлын төрөл, хэмжээ (2023 оны 10 сарын 01 байдлаар)			
Хог хаягдлын төрөл	Хэмжээ	Зайлуулсан арга хэмжээ	
1	Хуванцар хаягдал	0.2 тн	Хотод авдаг цэгт өгсөн
2	Цаасан хайрцаг	0.05 тн	Дахин ашигласан
3	Хүнсний хаягдал	0.9тн	Хогийн цэгт хүргэсэн
4	Үнс	42 тн	Хогийн цэгт хүргэсэн
6	Ашигласан хүнсний тос	0.8 тн	Дахин ашигласан
7	Бусад	1.3 тн	Хогийн цэгт хүргэсэн
8	Хаягдал дугуй	20 ш	Хаягдал дугуй хадагалах цэгт хадгалж байгаа.
9	Ажилласан тос масло	4640 л	Зориулалтын саванд хадгалж байгаа
10	Төмөр	258 тн	Төмөр хадгалах цэгт хадгалж байгаа



Зураг 38. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах хог хаягдлыг цуглуулах цэг байгуулсан.



Зураг 39. Тэсэлгээнээс гарах хог хаягдал буюу шуудайг тэсэлгээний агуулахын хажууд хаалт бүхий хогийн цэгт түр хадгалаад, устгадаг.



Зураг 40. Ахуйн байрны хог хаягдал ангилан цуглуулах сав



Зураг 41.Хаягдал дугуй болон хаягдал төмрийн цэг



Зураг 42. Техникийн хаягдал тос, масло, тосол зэрэг шингэн хог хаягдал болон бусад хог хаягдлыг ангилан ялгаж байна.

2.8 БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРШИН СУУГЧ ОРОЛЦОГЧ ТАУУДАД ТАЙЛАГНАХ

Төлөвөлгөө		Гүйцэтгэл
1	-Сум, багийн ИНХ-д уулзалт санал асуулга	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлж байна.
2	- Даланжаргалан сумын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчид 2023 оны БОМТ-ний хэрэгжилтийн тухай тайлагнах	2023 оны БОМТ –ний биелэлтийн тайланг баталгаажуулсаны дараа орон нутгийн бүх шатны мэргэжлийн байгууллагад тайлагнана.
3	-БОАЖЯ-ны ХБОБНУГ-т БОМТ-ний биелэлтийг тайлагнах	2023 оны БОМТ –ний биелэлтийн тайланг баталгаажуулсаны дараа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Төлөвөлгөө		Гүйцэтгэл
1. Агаарын чанар		
1	-Жилд 1 удаа Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар Төсөл хэрэгжих талбайд хяналтын 4 цэг сонгон $X1= 108^{\circ} 46' 0.969''$ $Y1= 45^{\circ} 53'32.969''$ $X2= 108^{\circ} 44'59.008''$ $Y2= 45^{\circ} 54' 12.596''$ $X3= 108^{\circ} 50'9.444''$ $Y3= 45^{\circ} 55'13.499''$ $X4= 108^{\circ} 48'0.725''$ $Y4= 45^{\circ} 51'51.198''$ хийлгэх	-Агаарын чанарын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх тохиолдлыг шалгах, хэмжилтийн мэдээний жилийн бичилт динамикийг гарагах зорилгоор агаар орчны тоосны агууламж органик бус хийн төлөвт бохирдуулагчид (хүхрийн исэл, азотийн исэл,) Агаарын чанарын шинжилгээ сорьц дээж авах ажлыг Дорноговь аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэргэжилтэн 2023.09.12-нд ирж 4 цэгт шинжилгээ хийсэн, шинжилгээнд Кемп орчмоос авсан шинжилгээнд: Хүхэрлэг хий- 0.002мг/м ³ , Азотын давхар исэл – 0.03мг/м ³ , нийт тоосны агууламж- 0.006мг/м ³ Баяжуулах үйлдвэр орчмоос авсан шинжилгээнд: Хүхэрлэг хий- 0.002мг/м ³ , Азотын давхар исэл – 0.027мг/м ³ , нийт тоосны агууламж- 0.029мг/м ³ .

		<p>Карьер орчмоос авсан шинжилгээнд: Хүхэрлэг хий-0.004мг/м3, Азотын давхар исэл – 0.046мг/м3, нийт тоосны агууламж- 0.021мг/м3.</p> <p>ШТС-ын орчмоос авсан шинжилгээнд: Хүхэрлэг хий-0.002мг/м3, Азотын давхар исэл – 0.016мг/м3, нийт тоосны агууламж- 0.020мг/м3. Шинжилгээнд стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.</p>
2.Хөрсний чанар		
2	<p>-Жилд 2 удаа Хөрсний механик бүтэц, Хими физикийн шинж чанар, Хүнд металлын агууламж</p> <p>Микро элементүүдийн шинжилгээ</p> <p>Төслийн талбайд 4 цэг сонгох</p> <p>ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн талбайд</p> <p>X1= 109° 06' 5.9"</p> <p>Y1= 45° 55' 52.2"</p> <p>X2= 108° 45'38.1"</p> <p>Y2= 45° 54' 11.7"</p> <p>X3= 108° 45' 54.4"</p> <p>Y3= 45° 53' 42.1"</p> <p>X4= 108° 45' 18.7"</p> <p>Y4= 45° 53' 42"</p>	<p>Хөрсний хими физикийн, механик бүрэлдэхүүн, эрүүл ахуй, хүнд металлын шинжилгээг төслийн талбайн 4 цэгээс авч Инженер-Геодизийн ХХК-ний лабораторид шинжлүүлсэн. Хөрсний хүнд металлын шинжилгээгээр стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна. Шинжилгээний үр дүнг хавсаргасан.</p>
3. Усны хяналт шинжилгээ		
3	<p>-Жилд 2 удаа Өөрийн 3 Гүний худаг, Билүүтийн худаг 4 цэгт усны шинжилгээ хийлгэх</p> <p>X1= 108°46'6.90"</p> <p>Y1=45°54'46.50"</p> <p>X2=108°45'53.50"</p> <p>Y2=45°54'45.60"</p>	<p>Төслийн усан орчны мониторингийн ажлыг гүний 2 худаг болон малчдын гар худагт усны чанарын шинжилгээ, түвшин хэмжилт гэсэн үндсэн 2 чиглэлээр хийлээ. Уурхайн орчмын ордын гүний ус нь хурдас чулуулгийнхаа найрлагыг усандаа шингээсэн байдаг учраас байгалиасаа эрдэжилт ихтэй, хатуулаг өндөртэй ус байдаг нь уурхайн өмнөх болон одоогийн хяналтын</p>

<p>X3=108°47'17.30" Y3=45°55'1.85" Хбилт=108°46'35.72" Үбилүт= 45°54'34.67"</p>	<p>шинжилгээний үр дүнгээс харагдаж байна. Шинжилгээний үр дүнг хавсаргасан.</p>
<p>4.Ургамлын аймаг</p>	
<p>-Жилд 1 удаа Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах зэрэгт Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт судалгаа хийх</p> <p>X6=108°44'18.852" Y61=45°54'58.072" X=108°49'49.662" Y62= 45° 53' 20.788</p>	<p>орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ургамлан нөмрөгийн судалгааг 3 цэгт хийж судалсан.</p> <p>Ургамлын бичиглэл: 1</p> <p>1-р цэгийн орчимд Дэрс улалж бүхий хээр: хур бороо ихтэй жил үерийн ус дайран өнгөрдөг, хонхор газруудаар борооны ус тогтож хөрсөнд сайн шингэдэг, үерийн усаар зөөгдөн ирсэн хужир мараа нь дэрс, улалж гэх мэт ургамлууд ургах таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Шарилжны төрлийн ургамлууд түгээмэл тохиолддог ба үүнээс хамгийн элбэг болох агиас шаргал шарилж, олон зүйлийн цэцэгт ургамлаар баялаг байна.</p> <p>Ургамлын бичиглэл: 2</p> <p>Нөлөөлөл: Тухайн ургамлын бичиглэл хийсэн цэг орчимд ургамлан нөмрөгт ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй байна.</p> <p>Харгана, бүйлс бүхий шарилжит: Хадархаг газар тохиолдох энэ эвшилд ямаан харгана, бүйлэс, тавилгана зэрэг бутлаг, шарилж, боролзой зэрэг сөөгөнцөр ургамал, хөмүүл, хунчир, шимэлдэг, ерөндгөнө, ажгана зэрэг өвслөг ургамлууд ургана.</p> <p>Бут сөөг нь ургамлын бүлгэмдэлд хамгийн тогтвортой бүрэлдэхүүн хэсэг бөгөөд газрын хөрсний дөрөвний нэг хувийг хамардаг тусгалын бүрхэцтэй. Эдгээр ургамлууд нь үрээр хооллогч хөхтөн амьтад, шувуу болон навч мөчрийг нь иддэг туруутан амьтдын шдэш тэжээлийн чухал эх үүсвэр болдог.</p>



Зураг 43. Кемп орчмоос дээж авсан



Зураг 44. ШТС орчмоос дээж авсан



Зураг 45. Овоолго орчмоос дээж авсан



Зураг 46. Карьер орчмоос дээж авсан



Зураг 47. Ургамлын бичиглэл 1



Зураг 48. Ургамлын бичиглэл 2



Зураг 49. Ургамлын бичиглэл 3

ХАВСРАЛТ

1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл
2. ТЭЗҮ тушаал, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны батлагдсан QR нүүр
4. Ус ашиглуулах дүгнэлт
5. Ус ашиглах гэрээ
6. Хаягдал усны дүгнэлт
7. Хаягдал ус хаях зөвшөөрөл
8. Ахуйн хог хаягдлын гэрээ
9. Аюултай хог хаягдлын гэрээ
10. Аюултай хог хаягдлын хүлээлцэх хуудас
11. Тоолуурын бичилт
12. БОХ 3 маягт
13. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн баримт
14. Газрын төлбөр, АМНАТ-ын төлбөрийн баримт, Усны төлбөр төлсөн баримт
15. Мод захиалсан баримт
16. Хөрс, ус, агаарын шинжилгээний хариу



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-021441*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Дорноговь аймаг /хот/-ийн

Даланжаргалан сум /дүүрэг/-ын

Худагт нэртэй газарт орших

4067.64 гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011724090 тоот гэрчилгээтэй

“Олон ихт баян” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2049.07.24 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ДАШЗЭВЭГ

УХ-2019 оны 7 сарын 24 өдөр

Улаанбаатар хот







0000351



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-021441

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2019.07.24, дуусах хугацаа 2049.07.24Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөвКадастрын хэлтсийн даргын 2019.07.24-ний 364 тоот шийдвэр	
002-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.07.24 – 2021.07.24 хүртэл	 2020.07.03
003-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.07.24 – 2022.07.24 хүртэл	 2021.07.26
004-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.07.24 – 2023.07.24 хүртэл	 2022.07.18
005-SPR	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөхКадастрын хэлтсийн даргын 2022.12.22-ний 114 тоот шийдвэр	 2022.12.22
006-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.07.24 – 2024.07.24 хүртэл	



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-021441

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	• Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2019.07.24	4067.64 Га	0 Га	1	108° 51' 21.58"	45° 56' 41.61"
				2	108° 51' 21.58"	45° 53' 1.62"
				3	108° 46' 41.69"	45° 53' 1.62"
				4	108° 46' 41.7"	45° 53' 31.63"
				5	108° 45' 1.59"	45° 53' 31.63"
				6	108° 45' 1.59"	45° 53' 1.62"
				7	108° 42' 53.69"	45° 53' 1.62"
				8	108° 42' 53.69"	45° 54' 31.61"
				9	108° 43' 41.69"	45° 54' 31.61"
				10	108° 43' 41.69"	45° 55' 31.61"
				11	108° 45' 56.59"	45° 55' 31.61"
				12	108° 45' 56.59"	45° 54' 56.62"
				13	108° 46' 36.8"	45° 54' 56.62"
				14	108° 46' 36.8"	45° 53' 46.1"
				15	108° 47' 44.2"	45° 53' 46.1"
				16	108° 47' 44.2"	45° 54' 26.59"
				17	108° 49' 41.68"	45° 54' 26.59"
				18	108° 49' 41.7"	45° 56' 41.62"

3
2019-07-24
Д.Мягмарсүрэн
КАДАСТРЫН ХЭЛТЭС
УХХ-0595

005-SPR	• Тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх Шийдвэрийн огноо: 2022.12.22	1902.92 Га	2164.71 Га	1	108° 51' 21.58"	45° 56' 9.2"
				2	108° 51' 21.58"	45° 54' 46.01"
				3	108° 49' 55.61"	45° 54' 46.02"
				4	108° 49' 55.61"	45° 54' 16.87"
				5	108° 48' 38"	45° 54' 16.89"
				6	108° 48' 37.96"	45° 53' 1.62"
				7	108° 46' 41.69"	45° 53' 1.62"
				8	108° 46' 41.7"	45° 53' 31.63"
				9	108° 45' 1.59"	45° 53' 31.63"
				10	108° 45' 1.59"	45° 53' 1.62"
				11	108° 43' 41.7"	45° 53' 1.62"
				12	108° 43' 41.71"	45° 53' 53.12"
				13	108° 44' 45.41"	45° 53' 53.12"
				14	108° 44' 45.43"	45° 54' 37.07"
				15	108° 45' 56.59"	45° 54' 37.05"
				16	108° 45' 56.59"	45° 54' 56.62"
				17	108° 46' 36.8"	45° 54' 56.62"
				18	108° 46' 36.8"	45° 53' 46.1"
				19	108° 47' 44.2"	45° 53' 46.1"
				20	108° 47' 44.2"	45° 54' 26.59"
				21	108° 49' 41.68"	45° 54' 26.59"
				22	108° 49' 41.7"	45° 56' 9.22"

Д.Мягмарсүрэн 2022.12.22
КАДАСТРЫН ХЭЛТЭС
УХХ-0595



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар

783

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 22-ний өдрийн т/20-05-07 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-021441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Олон ихт баян ХХК-ийн Худагт нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.
2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.
4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.
5. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-021441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Худагт нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Олон ихт баян ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



53700951



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар Т/20-05-07

Улаанбаатар хот

Дорноговь аймгийн
Даланжаргалан сумын нутагт
орших MV-021441 тоот
ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй Худагт төмрийн
хүдрийн ордыг ил аргаар ашиглах
төслийн техник-эдийн засгийн
үндэслэл хэлэлцсэн тухай

“Олон ихт баян” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Прожект майнинг” ХХК боловсруулсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-021441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Худагт төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг Монгол улсын зөвлөх инженер Д.Эрдэнэчимэг зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Б.Бадамдорж шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн танилцуулга, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн олборлолт, Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөлмөр зохион байгуулалт, ажиллах хүч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Зах зээлийн судалгаа, Төслийн эдийн засгийн тооцоо зэрэг 11 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 203 хуудас тайлбар бичиг, 19 хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Ордын нөөцийг УУХҮЯ, АМГТГ-ын дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар Худагтын төмрийн хүдрийн ордын бодитой (В) нөөцийг 7120736 тн, боломжтой (С) нөөцийг 1742416 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 8863152 тн гэж улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 3% (131906 тн), бохирдлыг 5 %-аар (213248 тн) авч тооцсон ба ордыг 5 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 8.22 сая.тн хөрс хуулж, 4.478 сая.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 1000 мян.тн бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 1.84 м3/тн байна.

00002445

4. Худагтын ордын геологи болон уул техникийн нөхцөл хөрсийг гадаад овоолгод хураах тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ. (Жилийн хүчин чадал нь 1000 мян.тн)

5. Тус уурхайд SD150F өрмийн машин 2ш, Doosan DX520 маркийн экскаватор автогрейдер 1ш, HBXG SD6N маркийн автосамосвал 10 ш, SDLG G9190 маркийн ачигч 1ш зэрэг үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

6. Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших MV-021441 дугаар бүхий Худагтын төмрийн хүдрийн ордыг бүрэн төлөөлөх чадвартай төмөрлөг кварцитын дээжүүдээс нийт 100кг жинтэй НТС-1, НТС-2, НТС-3 дээжүүдийг авч төмрийн хүдрийн баяжигдах чанарыг тогтоох зорилгоор лабораторийн түвшний туршилт судалгааг БНХАУ-ийн Yantai Xinhai уул уурхайн зураг төсөл болон судалгааны газар технологийн туршилтын ажлыг явуулсан.

7. Технологийн туршилтын ажлыг дээжийн бодисын найрлагын судалгаа, анхдагч хүдэрт хийгдсэн химийн шинжилгээний үр дүнг үндэслэн соронзон сеперацийн аргыг сонгон авч гүйцэтгэсэн байна. Нойтон соронзон сеперацийн аргаар баяжуулсан туршилтаар 65% агуулгатай баяжмал гарган авах боломжтой болохыг тогтоосон байна.

8. Худагтын ордын хүдэр баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 1 сая.тн байна. Баяжуулах үйлдвэр нь төслийн нийт хугацаанд төмрийн 29.87% агуулгатай 4.478 сая.тн хүдэр баяжуулж төмрийн 65%-ийн агуулгатай 1.227 сая.тн төмрийн баяжмал гаргахаар тооцжээ.

9. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5914:2008, MNS5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт болон хаалтын зардалд нийт 3.55 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах бэлтгэл ажлын зардалд 35 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 536.2 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 259.1 сая төгрөг, хяналт шинжилгээ, магадалгааны зардалд 226.98 сая төгрөг, дүйцүүлэн нөхөн сэргээх зардалд 75 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 2.42 тэрбум төгрөг зарцуулахаар тусгажээ.

11. Уурхайн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ 39.75 тэрбум төгрөг, нэмэлт хөрөнгө оруулалт 15.57 тэрбум төгрөг бөгөөд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 55.33 тэрбум төгрөг байна.

12. Төслийн нийт хугацаанд 305.21 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 188.55 тэрбум төгрөгийн зардал гарган, 85.265 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж, хөрөнгө оруулалтаа ашиглалтын 2 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ.

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 04 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар: 65

Улаанбаатар хот
Утас: 51-265530

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Олон ихт баян" ХХК, захирал Б.Балдорж, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, 5-р хороолол нарны зам 75. Утас: 8801-3697. улсын бүртгэлийн дугаар: 9011724090, регистрийн дугаар: 6287727.

2. Төслийн нэр, байршил

"Худагт" төмрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км, Чойр хотоос зүүн тийш 75 км, Даланжаргалан сумын төвөөс 30 км, төмөр замын 25-р зөрлөг буюу Олон овоотоос баруун өмнө зүгт 22 км зайд байрлана. Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч

"Олон ихт баян" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021441, талбайн хэмжээ: 4067.64 га

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	108°51'21.58"	45°56'41.71"	10	108°43'41.69"	45°55'31.61"
2	108°51'21.58"	45°53'1.62"	11	108°43'41.69"	45°54'31.61"
3	108°46'41.69"	45°53'1.62"	12	108°42'53.69"	45°54'31.61"
4	108°46'41.7"	45°53'31.63"	13	108°42'53.69"	45°53'01.62"
5	108°45'1.59"	45°53'1.62"	14	108°45'01.59"	45°53'01.62"
6	108°42'1.59"	45°53'1.62"	15	108°45'01.59"	45°53'31.62"
7	108°42'53.69"	45°53'1.62"	16	108°46'41.70"	45°53'31.62"
8	108°42'53.69"	45°54'31.61"	17	108°46'41.69"	45°53'01.62"
9	108°43'41.69"	45°54'31.61"	18	108°51'21.57"	45°53'01.62"

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний 2 дугаар хавсралтад нийт 18 цэгээр лицензийн талбайг тогтоосон байна.

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт

Төмрийн хүдрийг олборлон, баяжуулах.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/

Уурхайн олборлолт, баяжуулах хэсэгт ажиллуулах машин техник:

<ul style="list-style-type: none"> • Doosan DX маркийн эксковатор 4 ш • Liugong MT маркийн автосамосвал 12 ш • Shantui SD-23 маркийн бульдозер 1 ш • Komatsu D155A маркийн бульдозер 1 ш • Liugong 870H маркийн утгуурт ачигч 2 ш • XCMG MS25 маркийн автосамосвал 1 ш • Liugong SWDE165A маркийн өрмийн машин 2 ш • PE1200x1500 маркийн хацарт бутлуур 1 ш • B1250 маркийн тэжээх төхөөрөмж 1 ш • PYYZ-300-A-32 маркийн конусан бутлуур 1 ш • PYYZ-500-D-50 маркийн конусан бутлуур 1 ш • TD75-10080 маркийн туузан конвейер 2 ш • TD75-12100 маркийн туузан гидрометаллурги 1 ш • 2YK3075 маркийн чичиргээт шигшүүр 1 ш • PG120-6 маркийн тэжээх төхөөрөмж 1 ш • NIS50-32-125 маркийн динамик насос 1 ш • MQGg3650 маркийн бөөрөнцөгт тээрэм 2 ш • ZKBX2460 маркийн чичиргээт шигшүүр 1 ш 	<ul style="list-style-type: none"> • LPIIIr250/200 маркийн динамик насос 1 ш • XPA150/125 маркийн динамик насос 1 ш • XPA80/80 маркийн динамик насос 1 ш • XC-300x8 маркийн гравитаци 1 ш • XC-150x12 маркийн гравитаци 1 ш • CTB-1230 маркийн нойтон сул соронзон сеп • CTB-1024 маркийн нойтон сул соронзон сеп • NZSG-15 маркийн өтгөрүүлэх, шүүх, хатаах • NT-20 маркийн өтгөрүүлэх, шүүх, хатаах төх • XAMY1050/2000-UBK маркийн хаягдал хура • OZJL-I-A33 маркийн динамик насос 1 ш • KQDL100x20x3 маркийн динамик насос 1 ш • 400V-SP маркийн динамик насос 1 ш
---	---

Төмрийн хүдрийг соронзон баяжуулалтаар баяжуулж, төмрийн баяжмал гарган авна. Уурхай хоногт 2 ээлжээр 20 цаг, нийт 233 хүн 335 хоног ажиллана. (2023 оны АҮАТ-ний Маягт-12, 14-р хуудас).

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ

2023 онд 3,028,180.0 м³ хөрс хуулж, 1,074,023.0 тн төмрийн хүдрийг олборлон, 1,000,000.0 тн хүдрийг баяжуулж, 299,200.0 тн төмрийн нунтаг баяжмал үйлдвэрлэнэ. Биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 ширхэг мод тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/

Унд, ахуй болон технологи, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах усыг нийт 12.67 л/сек ундаргатай 3 ширхэг гүний худгаас, зам талбайн тоосжилт дарахад ашиглах усыг хаягдал ус цэвэршүүлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усаар хангана. Унд ахуйд хоногт 34.95 м³ ус хэрэглэнэ.

Монгол Ус ТӨҮГ-ын 2020.07.31-ний өдрийн 01/367 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд төслийн 2,204.38 м³/хон усны хэрэглээг 1,036.8 м³/хон ундаргатай гүний 1 худгаас, мөн уурхайд шүүрч орж ирэх 7,240.32 м³/хон шүүрлийн уснаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна гэсэн.

Худагт нэртэй төмрийн хүдрийн ордын гидрогеологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланд 1232 метр гаруй өндөртэй уулын оройд буюу ус хагалбарын хэсэгт байрлах ордын шавхалт-туршилтын үр дүнгээр уст үеийн зузаан нь 110 метрээс доош гүнд орж ирэх бөгөөд ордыг 200 метр гүн хүртэл олборлоход газар доорх усны шүүрэлтийн тооцоог том худгийн аргаар, даралтад гадаргатай усны горимоор тооцоо хийхэд ашиглалтын үед хамгийн гүндээ буюу 200 метр хүрэх үед хамгийн ихдээ 7,384 м³/хон ус орж ирнэ гэж тооцоолсон.

2023 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр өндөржилт 1180 м-1234 м хооронд буюу уурхайн гүн 54 метр доошлохоор байна.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/

Цэвэр усны сан 1324 м³ багтаамжтай, эргэлтийн усан сан 3x1780 м³ багтаамжтай, өтгөрүүлэгчийн хаягдлын сан 5528 м³ багтаамжтай. Гүний худгуудаас ус дамжуулах 150 мм голчтой, 600 м урт, 125 мм голчтой, 600 м урттай ган хоолойтой.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, /насосны хүчин чадал, марк/

Худгийн нэр	Уртраг	Өргөрөг	Ундарга, л/сек	Тоолуурын марк
Худаг D1	108°46'06.9"	45°54'46.5"	8.17	LXSG-32
Худаг D4	108°45'53.5"	45°54'45.6"	2.5	LXSG-32
Худаг D5	108°47'17.3"	45°55'1.85"	2.0	LXSG-32

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл

"Худагт" төмрийн ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2021 онд "Саблайм" ХХК хийж гүйцэтгэсэн.

12. Онцгой нөхцөл

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах.
- Нөхөн сэлбэлтээр авах усны хэмжээг 20 %-иас хэтрүүлэхгүй байх;

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд жилд:

$$1,000,000.0 \text{ тн/жил} \times 3.4 \text{ м}^3/\text{тн} = 3,400,000.0 \text{ м}^3 \text{ ус шаардана.}$$

Хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: 1,000,000.0 тн/жил (БОННУ-ийн 42-р хуудас). Нийт шаардагдах усны 80%-ийг буюу 2,720,000.0 м³ усыг эргэлтээр, **20% буюу 680,000.0 м³** усыг нөхөн сэлбэлтээр хангана (БОННУТ 46-р хуудас).

Унд, ахуйн усны нийт хэрэгцээнд:

233 хүн x 150 л/хон x 335 хон = **11,708.25 м³**

10,675.0 м ² x 2 л/м ² x 180 хон = 3,843.0 м³	зам, талбайн тоосжилт дарах усны хэмжээ (БОННУТ 46-р хуудас, ашиглалтын 2 дахь жил)
500 ш x 50 л x 18 удаа = 450.0 м ³	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод услах усны хэмжээ
200 ш x 50 л x 18 удаа = 180.0 м ³	урьд жилүүдэд тарьсан мод усалгаанд ашиглах ус
450.0 м ³ + 180.0 м ³ = 630.0 м³	Ногоон байгууламж, мод тарихад ашиглах нийт усны хэмжээ
680,000.0 м³ + 3,843.0 м³ + 630.0 м³ = 684,473.0 м³	Технологи, зам талбай, мод услахад шаардлагатай нийт усны хэмжээ

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны төлбөрийн хэмжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах **11,708.25 м³/жил** усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал олборлон баяжуулахад **680,000.0 м³/жил**, зам талбайн тоосжилт дарахад **3,843.0 м³/жил**, нөхөн сэргээлт, ногоон байгууламж, мод услахад ашиглах **630.0 м³/жил** газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326, 2022 оны 416 дугаар тогтоолд заасан хувь, хэмжээг ашиглан усны нөөц ашигласны төлбөрийг урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал олборлон баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

1 м³ газрын доорх усны үнэ: 3,700.0 төг/м³ x 0.35 x 1.8 = 2,331.0 төг

3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

35 %: Засгийн газрын 326-р тогтоолын 7а-д заасан газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь хэмжээ;

1.8: Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт ашигт малтмал олборлон баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

680,000.0 м³ x 2,331.0 төг/м³ = 1,585,080,000.0 төг

Зам, талбайн тоосжилт дарахад усны нөөц ашигласны төлбөр:

1 м³ газрын доорх усны үнэ: 3700 төг/м³ x 0.2 x 0.25 = 185.0 төг/м³

- 3700 төг/м³ – Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
- 20 % – Засгийн газрын 326-р тогтоолын 9-т заасан авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
- 0.25 – Авто замын тоосжилт дарах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

3,843.0 м³ x 185.0 төг/м³ = 710,955.0 төг

Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, мод тарихад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3.700.0 \text{ төг/м}^3 \times 0.1 \times 0.2 = 74 \text{ төг}$

- 3,700.0 төг/м³: Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
- 10 % – Засгийн газрын 326-р тогтоолын 9-д заасан газар тариалангийн үйлдвэрлэлд газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;
- 0.2 – Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$630.0 \text{ м}^3 \times 74 \text{ төг/м}^3 = 46,620.0 \text{ төг}$

Нийт төлбөр: 1,585,080,000.0 төг + 710,955.0 төг + 46,620.0 төг = 1,585,837,575.0 төг

/Нэг тэрбум таван зуун наян таван сая найман зуун гучин долоон мянга таван зуун далан тав/

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, халдваргүйжүүлэн зам, талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

16. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрт баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, зураг төсөлд Усны газраар 2023 онд багтаан дүгнэлт гаргуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.МЭНДБАЯР

БАТЛАВ:
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА

Б.ОТГОНСҮРЭН/

БАТЛАВ:
“ОЛОН ИХТ БЯАН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:

Б.БАЛДОРЖ/

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 04 сарын 27-ний өдөр

Дугаар- 11

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дугаар зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын гаргасан 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 65 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн А/18 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Солонго, Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19-р хороо, “Хүрд интернейшнл” ХХК-ны байр. 9011340010 улсын бүртгэлийн дугаартай, 5570646 регистрийн дугаартай “Олон ихт баян” ХХК-ийн уурхайн дарга Ж. Цэвэгмэд нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

MV-021441, талбайн хэмжээ: 4'067.64 га, Төмрийн хүдрийг олборлон, баяжуулах. 2023 онд 3'028'180 м³ хөрс хуулж, 1'074'023 тн төмрийн хүдрийг олборлон 1'000'000.0 тн хүдрийг баяжуулж, 299'200 тн төмрийн нунтаг баяжмал үйлдвэрлэнэ. Биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 ширхэг мод тарина.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 696'181.25 м³/жил

2.2.1. Унд ахуйд: 11'708.25 м³/жил

2.2.2 Баяжуулах үйлдвэрт: 680'000.0 м³/жил

2.2.3 Зам талбайн тоосжилт: 3843 м³/жил

2.2.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод усалгаанд: 630 м³/жил

2.3. Усны чанар, найрлага: Монгол Ус ТӨҮГ-ын 2020.07.31-ний өдрийн 01/367 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд төслийн 2'204м³/хон усны хэрэглээг 1'036.8м³/хон ундаргатай гүний 1 худгаас, мөн уурхайд шүүрч орж ирэх 7'240.32м³/хон шүүрлийн уснаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

2.4. Усны эх үүсвэр: Унд ахуй болон технологи, ногоон байгууламжийн ашиглах усыг Сэнжит худаг болон Шанаган могойт нэртэй 2 ордын талбайд байрлах нийт 12.67 л/сек ундаргатай 3 ширхэг гүний худгаас хангана. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усыг ахуйн бохир ус

цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн саарал усаар хангана. Унд ахуйд хоногт 34.95 м³/хон ус хэрэглэнэ.

2.4.1. Байршил: Дорноговь аймгийн Даланжаргалан сум, төмөр замын 25-р зөрлөг буюу Олон овоотоос баруун зүгт 22 км орчим зайд байрладаг.

2.4.2. Солбицол:

№	Худгийн нэр	Уртраг	Өргөрөг	Ундарга л/сек	Тоолуурын марк
1	Худаг D1	108°46'06.9''	45°54'46.5''	8.17	LXSG-32
2	Худаг D2	108°45'53.5''	45°54'45.6''	2.5	LXSG-32
3	Худаг D3	108°47'17.3''	45°55'1.85''	2.0	LXSG-32

2.4.3. Барилга байгууламж: Цэвэр усны сан 1'324 м³ багтаамжтай, эргэлтийн усан 3x1'780 м³ багтаамжтай, өтгөрүүлэгчийн хаягдлын сан 5'528 м³ багтаамжтай. Худагтын газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн голч 150мм, урт 600м урт, 125мм-ийн 600м урттай ган хоолойгоор тус тус дамжуулна.

2.4.4. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Эргэлтийн усан сангийн 3ш тогооны багтаамж тус бүр 1'780м³, өтгөрүүлэгчийн хаягдал бүхий хаягдлын тогооны багтаамж 5'528м³, цэвэр усан сангийн багтаамж 1'324.0м³ байна.

2.5. Хаягдал ус: Унд ахуйгаас гарах бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулдаг.

Хаях цэгийн байршил: Үйлдвэрийн талбай

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг:.....

Органик бодис, кг:.....

Эрдэс бодис, кг:.....

Хүнд металл, кг:.....

Аюултай бохирдуулах бодис, гр:.....

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур: Худагт LXSG-32 маркийн тоолууртай.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын дагуу ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх 10'731.0 м³/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал олборлох, баяжуулах газрын доорх ус ашиглах усны төлбөр:

$$1\text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{ төг/м}^3 \times 0.2 \times 1.8 = 2'331 \text{ төг/м}^3$$

- 3'700төг/м³- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

- (35%)- Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7(а) газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/
- 1.8- Ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$680'000.0 \text{ м}^3/\text{жил} \times 2'331 \text{ төг}/\text{м}^3 = 1'585'080'000 \text{ төгрөг}$$

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700 \text{ төг}/\text{м}^3 \times 0.2 \times 0.25 = 185.0 \text{ төг}/\text{м}^3$$

- $3'700 \text{ төг}/\text{м}^3$ - Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (20%)- Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 9-т заасан авто замын зориулалтаар тооцох газрын доорх усны хувь хэмжээ.
- 0.25- Авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$3'843 \text{ м}^3 \times 185.0 \text{ төг}/\text{м}^3 = 710'955 \text{ төгрөг}$$

Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, мод тарихад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700 \text{ төг}/\text{м}^3 \times 0.1 \times 0.2 = 74.0 \text{ төг}/\text{м}^3$$

- $3'700 \text{ төг}/\text{м}^3$ - Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (10%)- Засгийн газрын 326-р тогтоолын 9-т заасан нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд тооцох газрын доорх усны хувь хэмжээ.
- 0.2 - Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$630 \text{ м}^3/\text{жил} \times 74.0 \text{ төг}/\text{м}^3 = 46'620.0 \text{ төгрөг}$$

$$\text{Нийт төлбөр} = 1'585'080'000 \text{ төг} + 710'955 \text{ төг} + 46'620.0 \text{ төг} = 1'585'837'575 \text{ төг}$$

/Нэг тэрбум таван зуун наян таван сая найман зуун гучин долоон мянга таван зуун далан таван төгрөг/

Баяжуулах үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах $696'181.25 \text{ м}^3/\text{жил}$ газрын доорх усны төлбөр $1'585'837'575 \text{ төгрөг}$ /Нэг тэрбум таван зуун наян таван сая найман зуун гучин долоон мянга таван зуун далан таван төгрөг/-ийг Дорноговь аймгийн Төрийн сан банкны 100060000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

Жич: Газрын доорх ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэрт байрлуулсан усны тоолуурын заалтаар, Даланжаргалан сумын Татварын хэлтсийн болон Байгаль орчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан сар бүрийн 20-25-ны дотор авч, дараа сарын 10-ны дотор төлнө.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2.2. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах.

3.2.3. Тухайн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн эхний болон эцсийн заалтыг акт, зургаар баталгаажуулалт хийж 1 хувийг Сав газрын захиргаанд ирүүлэх.

3.2.4. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг Сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.5. Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх.

3.2.6. “Усны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтуудын дагуу аж ахуй нэгж байгууллага нь газрын доорх усны дотоод хяналтын цэгийг байгуулна;

3.2.7. Нөхөн сэлбэлтээр авах усны хэмжээг 20%-иас хэтрүүлэхгүй байх;

3.2.8. Ажилчдын ундны усыг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, улиралд 1 удаа байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.9. Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;

3.2.10. Хаягдлын сангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, зураг төсөлд Усны газраар 2023 онд багтаан дүгнэлт гаргуулах;

3.2.11. Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар болон Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.12. Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;

3.2.13. Ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, халдваргүйжүүлэн зам, талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2.14. Гэрээнд заасан хэмжээнээс илүү ус ашигласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

3.2.15. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн болон төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2023 оны 12 дугаар сарын 30-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанарчанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн:

...../Н. Солонго/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг, Ногоон хөгжлийн төв, 205 тоот
Харилцах утас: 7054-3598

Ус ашиглагчийг төлөөлж:

“Олон их баян” ХХК-ийн уурхайн дарга

...../Ж. Цэвэгмэд/

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 19-р хороо, Хурд интернейшнл ХХК-ны байр
Харилцах утас: 9988-5833

/арван дөрвөн сая тавин таван мянга долоон зуун арван есөн төгрөг гучин таван мөнгө/
ногдож байна.

7. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ

-Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт – Халхын дундад талын сав газрын захиргаагаар "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг", "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ"-г дүгнүүлж, сунгуулах;

-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал"-ын хүснэгт №2-ын 16, 32-т заасан хаягдал усанд тодорхойлох үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй тохиолдолд бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр авч тооцно;

-"Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, стандартаас давсан бол Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан есгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулна;

Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд e-mongolia цахим системээр ирүүлэх;

-Улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;

-Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх;

-Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Усны газрын office@water.gov.mn цахим хаягаар 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХЗУЛ

Б.АМАРТАЙВАН

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2023 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар: 95

Улаанбаатар хот
Утас: 51-265540

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Олон ихт баян" ХХК-ийн захирал Б.Батболд, холбоо барих утасны дугаар 99975617 88013697, улсын бүртгэлийн дугаар 9011724090, регистрийн дугаар 6287727.

2. Төслийн нэр, байршил

"Олон Ихт Баян" ХХК-ийн Худагтын төмрийн орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос 300 км, Говьсүмбэр аймгаас зүүн урагшаа 75 км, төмөр замын 25-р зөрлөг буюу Олон овоотоос баруун зүгт 22 км зайд байрладаг бөгөөд Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарч байна.

3. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин:

"Олон Ихт Баян" ХХК-ийн Худагтын төмрийн ордын уурхай нь технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг $5,528 \text{ м}^3$ эзлэхүүнтэй хаягдлын сан, тус бүр $1,780 \text{ м}^3$ эзлэхүүнтэй эргэлтийн усан санд хуримтлуулан байгалийн өөрөө цэвэрших энгийн биологийн аргаар цэвэрлэн технологид эргүүлэн ашигладаг ба унд ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулдаг байна.

4. Хаягдал усны хэмжээ:

Тус компанийн ус ашиглах гэрээ дүгнэсэн актыг үндэслэн хаягдал усны эзлэхүүнийг унд ахуйд $7,820.00 \text{ м}^3/\text{жил}$, технологид $75,554.00 \text{ м}^3/\text{жил}$ байхаар тооцов.

5. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:

Технологийн хаягдал усанд IV улиралд, унд ахуйн хаягдал усанд III, IV улиралд сорьцын шинжилгээ хийлгээгүй тул Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн бохирдуулах бодисын хэмжээг унд ахуйд ажилчдын хотхон $1.5 \text{ кг}/\text{м}^3$, технологид бусад үйлдвэрлэл $0.8 \text{ кг}/\text{м}^3$ -ээр тооцов.

Бохирдуулах бодисын төрөл	Улиралд хийсэн шинжилгээний давтамж	ЗДХ	Бохирдуулах бодисын агууламж
			Технологи III улирал
Жинлэгдэх бодис	1	30	57.00
Органик бодис /XXX/	1	50	911.00
Органик бодис /БХХс/	1	20	350.38
Органик бодис /нийт азот/	1	15	1.11

6. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн Сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/635 тоот тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ыг тус тус үндэслэн тооцоход **14,055,719.35**





БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА**


42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3599,
И-мэйл: umardgobi14@gmail.com, Вэбсайт: www.gobiwater.mn

2023.06.20 № 281
танай _____-ны № _____-т

“ОЛОН ИХТ БАЯН” ХХК-Д

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч
Агентлаг Усны Газрын 2023 оны 05 дугаар сарын
29-ны өдрийн 95 дугаартай хаягдал усны дүгнэлтийг
үндэслэн 2022 оны хаягдал ус хаях зөвшөөрөл
олгож, төлбөрийн гэрээг байгуулан хавсралтаар
хүргүүлж байна.

Хувийг: Дорноговь аймгийн Татварын хэлтэст
Хавсралт хуудастай.

ДАРГА  Б. ОТГОНСҮРЭН

БАТЛАВ:

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ - ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА

 /Б.ОТГОНСУРЭН/

БАТЛАВ:

“ОЛОН ИХТ БАЯН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

...../Б.БАТБОЛД/

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 06 сарын 20-ны өдөр

Дугаар-14

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны гаргасан 202... оны -р сарын-ны өдрийн дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н. Солонго, нөгөө талаас Ус бохирдуулагчийг төлөөлж: Дорноговь аймаг, Даланжаргалан сум, “Олон ихт баян” ХХК-ны байр. 9011724090 улсын бүртгэлийн дугаартай, 6287727 регистрийн дугаартай “Олон ихт баян” ХХК-ийн уурхайн дарга Ж. Цэвэгмэд нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин.Усны чанар.Хаягдал ус.Ерөнхий шаардлага” MNS4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.
- 2.2. Ус бохирдуулагч нь “Усны тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын нормтив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын нормтив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.
- 2.3. Төлбөр төлөгч нь “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах Татварын албанд төлнө.

“Олон Ихт Баян” ХХК-ийн 2022 оны ус бохирдуулсны төлбөрийн нийт дүн: 83'374.0м³ усанд 14'055'719.35 төгрөг /Арван дөрвөн сая тавин таван мянга долоон зуун арван есөн төгрөг гучин таван мөнгө/ ноогдуулсныг үндэслэв. /Усны газрын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 95 дугаартай хаягдал усны дүгнэлт үндэслэв/

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.3.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.3.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.3.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан;

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн “Усны тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шагны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал

усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

- 5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

- 6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

 /Н.Солонго/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг, Ногоон хөгжлийн төв, 2-р давхар, 205 тоот
Харилцах утас: 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

“Олон ихт баян” ХХК-ийн уурхайн дарга

 /Ж.Цэвэгмэд/

Хаяг: Дорноговь аймаг, Даланжаргалан сум, “Олон ихт баян” ХХК-ны байр
Харилцах утас: 9988-5833, 8801-3697



ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2023 оны 02 сарын 28-ны өдөр

№05

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 20.1, 20.2, Сумын ИТХ-ийн 2022 оны 12 сарын 12 өдрийн 11/07 тоот тогтоолыг үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ-ыг төлөөлж БОБМэргэжилтэн ажилтай С.Дандарбаатар нөгөө талаас “Олон Ихт Баян” ХХК-ийн /Улаанбаатар хот БЗД-н 19- хороо, цайзын задгай “хурд интэрнэйшнл” улсын бүртгэлийн 9011724090 гэрчилгээтэй / Үйлдвэрийн дарга Н.Тэгшжаргал нар харилцан тохиролцож 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 сарын 31-ийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Төлбөр тооцсон байдал:

Далажаргалан сумын ИТХ-ийн 2023 оны 12/12 тоот тогтоолын 1-р хавсралтад заасан: 1 сарын төлбөр 500,000 төгрөг, баяжуулах, угаах, боловсруулах үйлдвэр гэсэн залтыг үндэслэн сарын /500,000 төлбөрийг тооцож

Ажилах хугацаа: 12 сар
Сарын төлбөр: 500,000 төг
Нийт: 6,000,000

Дөрөв. Сумын ЗДТГ эрх

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасаны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

Тав. Иргэн, ААН байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
2. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15 ний дотор гэрээнд зааснаар Төрийн сан банк 100060300947 тоот дансанд тогтмол шилжүүлж байна.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох;
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх


Зургаа.Гэрээний хариуцлага

6.1.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

6.2.Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Даланжаргалан сумын
БОБМэргэжилтний үүргийг
түр орлон гүйцэтгэгч



/С.Дандарбаатар/
Утас:95106580

“Олон Ихт Баян”ХХК -н
урхайн дарга



/ Н.Тэгшжаргал /
утас: 89452489

БАТЛАВ: УЛААНБААТАР ХОТ
“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. Энхбадрал
Б.ЭНХБАДРАЛ
117250399
СБТ1561



Д. БАУЫРЖАН

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-23/ 75

2023 оны 09-р сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас “Элемент” ХХК / РД:2100061/ /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа нөгөө талаас /цаашид захиалагч гэх/-ыг “Олон Ихт Баян” ХХК /РД: 6287727/-ийг төлөөлж ХАБЭА албаны дарга М. Ганбаатар бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баглагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгахад оршино.
- 1.2. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1. Захиалагч дараах эртэй:
 - 2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
 - 2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
 - 2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.
- 2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
 - 2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
 - 2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
 - 2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,
 - 2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,
 - 2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
 - 2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,
 - 2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

- 2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтад хяналт тавих тус тус үүрэгтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:
- 3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
- 3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,
- 3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,
- 3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй
- 3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:
- 3.2.1. Аюултай хог хаягдлыг ачиж тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,
- 3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,
- 3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,
- 3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,
- 3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах
- 3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,
- 3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрд тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.
- 4.2. Захиалагч аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулахдаа гэрээний баталгаа болгож 500,000.0 /Таван зуун мянга/ төгрөгийг 4.3. дахь заалтад заасан дансанд байршуулна. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.
- 4.3. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачил тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.
- 4.4. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор “Элемент” ХХК-ийн 1715164140 /Голомт банк/ тоот дансанд төлнө.
- 4.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой объектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,

УЛААН
ЭЛБ
Х
1117
2100061
1525

- 4.6. Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлснээс үүдэх хохирлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.
- 4.7. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг 1 жил буюу 2023 оны 09 дүгээр сарын 12 -ны өдрөөс 2024 оны 09 -р сарын 12 -ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Энэхүү гэрээний 4.7-т заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.
- 5.2 Энэхүү гэрээний 4.8-д заасан хугацаанд гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.
- 5.3 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.
- 6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.
- 7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

- 8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгээр, амаар болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 9.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна.
- 9.2. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:
